



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/07

Даланзадгад

Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж
үйлчилгээг хөгжүүлэх 2019 оны аймгийн төлөвлөгөө
батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх 2019 оны аймгийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын болон орон нутгийн төсөв, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын хандив тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс /М.Цэндсүрэн/, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч наарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага арга зүйгээр хангаж, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Ж.Огтонбайгал/, Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Д.Дүүмаам/ наарт тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 02 сарын 11-ний өдрийн
А/07 тоот тушаалын хавсралт

9847751

СУВИЛАХҮЙ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ 2019 ОНЫ АЙМГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Сувилагч, тусгай мэргэжилтний манлайллыг сайжруулан, сувилахуй, тусгай мэргэжлийн тусlamжийн чанар, аюулгүй байдал, мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцаа хандлагыг өндөржүүлэх

Хэрэгжүүлэх хүрээ: Өмнөговь аймгийн нийт эрүүл мэндийн байгууллагууд, сувилагч тусгай мэргэжилтнүүд, эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан	Хэрэгжих хугацаа
Үйл ажиллагааны чиглэл 1		Нийгмийн эрүүл мэнд				
1.1	1. НЭМ-ийн сувилагч нарын үзүүлэх сургууль, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	Эмнэлэг бүрээс 1 сувилагч 19 сувилагч хамрагдана.	НЭМТ	НЭМ-ийн сувилагч нар	4 сар
Үйл ажиллагааны чиглэл 2		Сувилахуйн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах				
2.1	2. Сувилахуйн тусlamж үйлчилгээний эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлага, алдаа гарахаас урьдчилан сэргийлэх, алдаанаас суралцах, гарсан алдааг бүртгэх мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулах	Зохион байгуулсан арга, хэмжээний тоо, төрөл	Ижил төрлийн 1 ажил ЭМБ-уудад хийгдсэн байна.	ЭМГ	ЭМБ-ууд	4 сар
	3. Чадамжтай баг - чадавхтай тусlamж аймгийн ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах	Удирдамж, тайлан	2	ЭМГ, БОЭТ	ЭМБ-ууд	4 сар
	4. Сувилахуйн тусlamж үйлчилгээний стандарт удирдамжуудын хэрэгжилтийг сайжруулах сургалт зохион байгуулах	Хөтөлбөр, тайлан	8	ЭМБ-ууд	ЭМГ	Улиралд 2 удаа
	5. Сувилахуйн тусlamж үйлчилгээнд 1 мэргэжилтэнд улиралд 3 удаа үнэлгээ хийж, дүгнэлтийг нэгтгэн, сайжруулж ажиллах	Ижил мэргэжилтний үнэлгээ хийсэн тоо, тайлан	1	ЭМГ	ЭМБ-ууд	6, 11 сар
	6. Сувилахуйн тусlamж үйлчилгээ	Хөтөлбөр, тайлан	6	ЭМБ-ууд	ЭМГ	2 сард 1

	үзүүлэгчдийн ёс зүй, харилцааны соёлыг сайжруулах сургалтыг тогтмолжуулах					удаа
Үйлчлүүлэгч төвтэй, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх						
2.2	7. Гэрийн сувилгаа шаардлагатай өрхийн үйлчлүүлэгчдэд сувилахуйн тусламж үзүүлэн, сувилахуйн карт хөтөлж, үр дүнд судалгаа хийж ажиллах	Судалгаа, судалгааны тайлан	Анхан шатны байгууллага бүр сард 5 өрхөд хурч үйлчилнэ.	ЭМБ-ууд	ЭМГ	5, 11 сард
	8. Сувилагч хэвшүүлэгч аймгийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг тооцож ажиллах	Төлөвлөгөө, тайлан	Мэргэжилтэн бүр “Мэргэжлийн хөгжилд миний хувь нэмэр” хувийн төлөвлөгөө”-тэй ажилласан байна.	ЭМБ-ууд	ЭМГ	1-12 сар
	9. Хүүхдийн зуны сувилал ажиллуулах	Удирдамж, тайлан	Өрх сумын 17 эмнэлэг	ЭМБ-ууд	ЭМГ	5-9 сард
	10. Сувилагчийн эрт үнэлгээ удирдамж боловсруулах, сувилагчдыг чадавхжуулах	Удирдамж, зохион байгуулсан сургалт	2	ЭМГ	ЭМБ-ууд	5, 9 сар
	11. Сувилахуйн судалгааны тэргүүлэх чиглэлд заасан сэдвээр судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Хийгдсэн судалгааны тайлан	1	ЭМГ	ЭМБ-ууд	5 сар
	12. Сувилахуйн бакалаврын орон нутгийн анги бурдүүлэн хичээллүүлэх	Суралцагчийн тоо	1	ЭМГ	ЭМБ-ууд	3, 9 сар
	13. Төрөлжсөн нарийн мэргэжлийн сувилагч, тусгай мэргэжилтийг бэлтгэх ажлыг зохион байгуулах	Суралцагчийн тоо	1	ЭМГ	ЭМБ-ууд	3, 9 сар
2.3	Сувилахуйн тусламж, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, чанаарын тогтолцоог бэхжүүлэх					
	14. Сувилахуй, тусгай мэргэжлийн чиглэлээр үндэсний сургалт, зөвлөгөөнд хамрагдах	Суралцагчийн тоо	2	ЭМГ	ЭМБ-ууд	5, 10 сар
	15. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний лавлагаа, мэдээллийн шуурхай байдлыг тодорхой болгож хангуулах	Лавлагаа мэдээллийг сайжруулсан ЭМБ	Байгууллага бүр 1 ажил	ЭМБ-ууд	ЭМГ	5, 11 сар
	16. Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр байгууллагын дотоод зохицуулалтыг сайжруулах, үйлчилгээний урсгалыг шуурхай зохицуулах, цахим цаг товлох, бүртгэх, цахимаар болон утсаар мэдээлэл, зөвлөгөө өгөх аргудыг хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл	Байгууллага бүр 2-оос дээш ажил	ЭМБ-ууд	ЭМГ	5, 11 сар
	17. Үйлчлүүлэгчийг хүлээн авах, эмнэлэг хооронд, тасаг хооронд шилжүүлэх, эмнэлгээс	Зохион байгуулсан арга	Байгууллага бүр 2-оос дээш ажил	ЭМБ-ууд	ЭМГ	5, 11 сар

	гаргах, шаардлагатай мэдээлэл, сувилахуйн зөвлөгөө өгөх, бичиг баримтын бүрдэлтийг шуурхай болгох ажлын арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжүүлэлтийг сайжруулж ажиллах	хэмжээний тоо, төрөл				
	18. Сувилахуйн түүх хөтлөлтийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах	Сургалтын удирдамж, тайлан	2	ЭМГ	ЭМБ-үүд	6 сар
	Үйл ажиллагааны чиглэл 3	Сувилахуйн хүний нөөцийг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх				
3.1	19. Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дутагдалтай байгаа газруудад тэтгэлэгт хамруулан хүний нөөцийг нэмэгдүүлэх	Үр дүнтэй хэрэгжсэн ажлын тайлан	Байгууллага бүр 1 ажил	ЭМБ-үүд	ЭМГ	1-12 сар
	20. Сувилагчийн туслах бэлтгэх сургалтыг орон нутагт зохион байгуулах	Гэрээ, тайлан	20 туслах сувилагч бэлтгэсэн байна	ЭМГ	ЭМБ-үүд	1-12 сар
	21. Тасгийн ахлах сувилагчийн ажлын байр, сувилагчийн постыг байгууллагын дотоод служжээнд холбогдсон компьютероор хангах	Цахим сүлжээнд холбогдсон постын тоо	БОЭТ-5 Анхан шатны ЭМБ-үүд- 1	ЭМБ-үүд	ЭМГ	1-12 сар
	22. Сувилагчийн постыг байгуулах	Сувилагчийн постын тоо	БОЭТ-5 Анхан шатны ЭМБ-үүд 1	ЭМБ-үүд	ЭМГ	1-12 сар
	Сувилагчийн ажиллах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх					
3.2	23. Сувилахуйн тусlamж үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтын судалгааны сан бүрдүүлж, хангалтыг сайжруулан ажиллах	Судалгааны сан, хангалтыг сайжруулсан байдал	Байгууллага бүр хангалтыг 10% сайжруулах	ЭМБ-үүд	ЭМГ	5, 11 сар
	24. Сувилагч, тусгай мэргэжилтний эрүүл мэнд, нийгмийн байдлыг дэмжих арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Байгууллага бүр 1 арга хэмжээ	ЭМБ-үүд	ЭМГ	5, 11 сар
	Үйл ажиллагааны чиглэл 4	Сувилахуйн тусlamж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бэхжүүлэх				
4.1	Сувилахуйн тусlamж, үйлчилгээний удирдлага, төлөөлөл, мэргэжлийн хяналтын тогтолцоог бүх шатанд бэхжүүлэх					
	25. БОЭТ-ийн сувилахуйн албыг бүрэн бүтэц бүрэлдэхүүнээр ажиллуулах	Албаны орон тоо	3	БОЭТ	ЭМГ	1 улирал
	26. Ахлах сувилагч нарыг ажил хавсарч хийлгэхгүй, өдрөөр ажиллуулах	Ахисан үзүүлэлт	1	ЭМБ-үүд	ЭМГ	1-12 сар
	27. Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг англи хэлний сургалтад хамруулах	Хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо	Нэгж бүр 1	ЭМБ-үүд	ЭМГ	1-12 сар

	28. Сувилахуйн албаны гишүүд, ахлах сувилагч нарыг удирдлага, менежментийн сургалтад хамруулах	Хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо	Нэгж бүр 1	ЭМБ-ууд	ЭМГ	1-12 сар
Сувилагчийн ажлын үнэлэмж, цалин, урамшууллыг нэмэгдүүлэх бүх талын дэмжлэг, туслалцааг хөгжүүлэх						
4.2	29. Төрийн дээд шагналтан сувилагч төрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Зохион байгуулсан ажлын тоо	Байгууллага бүр 1	ЭМБ-ууд	ЭМГ	1, 6 сар
	30. ЭМБ-ын өвөрмөц нөхцөл байдалд тохирсон сувилагчийн ажлын ачааллын үнэлгээг хийж, үнэлэмжийг нэмэгдүүлэх дотоод зохион байгуулалтыг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны тайлан	ЭМБ бүр	ЭМБ-ын удирдлагууд	ЭМГ	1-12 сар
Сувилахуйн тусламж үйлчилгээний санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх						
4.3	31. Эмч, сувилагчийн харьцааг 1:2 зорилтын хүрээнд сувилагчийн тоог нэмэгдүүлэх байгууллагын төсөвт нэмж суулгах	Нэмэгдсэн сувилагчийн тоо	БОЭТ- 10, Ханбогд, Цогтцэций- 5 Бусад эмнэлэг шаардлагатай тоогоор	ЭМБ-ууд	ЭМГ	1, 7 сар
	32. Уул уурхай хөгжсөн эмнэлгүүдэд сувилахуйн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах төсөл боловсруулж, Уул уурхайн компаниуд, ЭМЯ-д санал хүргүүлж, асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт	Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумын эмнэлгүүдэд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн байна.	ЭМБ-ууд	ЭМГ	2-6 сар
	33. Сувилагч тусгай мэргэжилтнийг орон сууц, нийгмийн асуудлыг шийдвэрлэх дэмжлэгт хамруулах	Хамрагдсан мэргэжилтний тоо	Байгууллага бүр 1	ЭМБ-ууд	ЭМГ	1, 6 сар
Сувилахуйн тусламж үйлчилгээнд гадаад, дотоод хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх						
4.4	34. Сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах туршлага судлах сургалт аяллыг гадаад оронд хамрагдах	Хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо	8	ЭМБ-ууд	АЗДТГ, НБХ	1 сар
	35. Сумдын ахлах сувилагч нарыг ISO олон улсын стандарт хэрэгжсэн байгууллагуудад туршлага судлах сургалтад хамруулан, шинэ туршлага хэрэгжүүлэх	Хамрагдсан ахлах сувилагчийн тоо	10	ЭМГ	Сум, өрхийн эмнэлгүүд	2 сар
	36. Сувилагчдыг олон улсын хурал, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах	Хамрагдсан мэргэжилтнүүдийн тоо	2	ЭМБ-ууд	АЗДТГ, НБХ	5, 8 сар